

Соёлын сэргэлт

Дорноговь аймагт соёлын сэргэлт эрчимтэй өрнөж байна. “Соёлын сэргэлт-2023” улсын хэмжээний аяныг угтан Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойн хүрээнд аймгийн Засаг даргын А/331 дугаар захирамжийн дагуу “Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийг 5-р сарын 6-ны өдрөөс 6-р сарын 19-ний өдрийг дуустал хугацаанд зохион байгуулж 14 сумын гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, худалдаа, нутгийн өв соёлын онцлогийг харуулсан урлагийн тоглолтыг зохион байгуулсан. “Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн тоглолт, үзэсгэлэн худалгааг танхимаар 7000 иргэнд, цахимаар 110.000 гаруй үзэгчдэд хүрэлцэн ирж сонирхсон. “Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн хаалтын арга хэмжээг “Соёлын сэргэлт-2023” аяны нээлтийн үйл ажиллагаатай уялдуулан 6-р сарын 19 ны өдөр “Эгшиглэнт говь-2023” гала тоглолтыг 162 ардын авьяастанг оролцуулан танхимаар 500 гаруй хүн, шууд дамжуулалтаар 10,000 гаруй хүн үзэж, шилдгийн шилдэг сумдыг тодруулсан.

“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрүүдийн шагналт байрууд:

1. Тэргүүн байр: Хатанбулаг сум-5 сая₮ өргөмжлөл, батламж
2. Дэд байр: Эрдэнэ сум-4 сая₮ өргөмжлөл, батламж
3. Гутгаар байр: Замын-үүд сум-3 сая₮ өргөмжлөл, батламж
4. Тусгай байр: Улаанбадрах сум-1 сая₮ өргөмжлөл, батламж

Тусгай байр: Хөвсгөл сум-1 сая₮ өргөмжлөл, батламж тус тус гардууллаа.

Аймгийн Засаг даргын А/331 тоот захирамжаар 18,760,000₮-ийг өргөмжлөл, шагналт байр болон шүүгчийн урамшуулалд зарцуулсан. “Эгшиглэнт говь” гала тоглолтын үеэр Соёл, урлагийн газрын нэрэмжит шагналаар Дэлгэрэх сум-500,0₮, Саран хөхөө театрын нэрэмжит шагналаар Зүүнбаян сумын Соёлын төв ордон-500,0₮, Музей сургалт судалгааны төвийн нэрэмжит шагналаар Өргөн сум-100,0₮ гардууллаа. Мөн Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдийг урамшуулсан.

“Соёлын сэргэлт-2023” аяныг Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейтэй хамтран 14 сумын 12100 хүнд соёлын үйлчилгээг үзүүллээ. “Золгоё доо”, “Өвгөдийн захиас”, “Ээж минь” язгуур урлагийн тоглолтыг “Алтай” хамтлаг, “Соёлын бүтээлч үйлдвэрлэл” Дорноговь аймгийн ЖДҮ-ийн үзэсгэлэн худалдаа “Хайрцагтай музей” боловсролын хөтөлбөр, “Дорноговь аймгийн гар урлал, урчуудын үзэсгэлэн” WR үзэсгэлэн “Монголын нэг өдөр” “Торгонд амилсан шүтээн урлаг” нүүдлийн үзэсгэлэн “Барлах урлаг” боловсролын хөтөлбөрүүдээр аймгийн 14 сумдыг хамруулан иргэдэд үйлчиллээ. “Соёлын сэргэлт-2023” Дорноговь аймагт зохион байгуулсан нээлтийн ёслолд Төрийн соёрхолт, ардын уран зохиолч Б.Б.Догмидын уран бүтээлийг түгээн дэлгэрүүлэх, түүнийг алдаршуулах аога хэмжээг хөтөлбөрийн нэг хэсэг болгон зохион байгууллаа. Арга хэмжээнд УБ хотоос МУ-ын ардын жүжигчин Г. Равдан, СГЗ Ш. Гүрбазар, Жүжигчин Энхдөл, Саранхөхөө театрын жүжигчин Даваахүү, Дариймаа нар оролцон зохиолчийн бүтээлээс уншиж ард иргэдэд хүргэн уран бүтээлчид ая дуугаа өргөлөө. Энэ үеэр орон нутгийн удирдлагууд МУ-ын Төрийн Соёрхолт, ардын уран зохиолч Балжирын Догмидод хүндэтгэл үзүүллээ. Түүнчлэн өгүүлэх урлагийн мастерууд урилгаар оролцож, уншигч зохиолчдын уулзалт хийж соёлын салбарын залуучуудын төлөөлөл 350 залуу уншигчдыг хамрууллаа. “Соёлын сэргэлт-2023” аймгийн Тамгын газраас 15,0 сая төгрөгөөр дэмжлэг үзүүллээ.





Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл Урлагийн газраас санаачлан “Нээлттэй Дорноговь” зорилтот жил, Говийн Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ой тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг Равжаа судлалын олон улсын эрдэм шинжилгээний VI хурлыг “НОЁН ХУТАГТЫН ӨВ: ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ” сэдвийн дор 2023 оны 06-р сарын 09-ний өдөр Чингис Хаан үндэсний музейд амжилттай зохион байгууллаа. Эрдэм шинжилгээний хурлын зорилго нь говийн ноён хутагтын намтар болоод зохиол бүтээл судлалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, судалгааны сүүлийн үеийн үр дүнг хэлэлцүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ноён хутагтын өвийн үнэ цэнэ, ач холбогдлыг тодруулах, аялал жуучлал, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад орших бөгөөд хурлын нээлтэнд УИХ гишүүн Б.Дэлгэрсайхан, Т. Энхтүвшин, СУИС-ын Соёл урлаг судлалын хүрээлэнгийн захирал доктор (Sc.D), профессор Ч. Алтанцэцэг нар оролцож нээлтийн үг хэллээ. Тус хуралд Монгол, Орос, Хятад улсын 32 эрдэмтэн судлаачдын илтгэл хэлэлцүүлэгдэж Шинжлэх Ухааны эрдэмтэн багш нар, нутгийн алдартнууд Монгол Улсын Ардын Жүжигчин Г. Равдан, Монгол Улсын Төрийн Шагналт зохиолч Ш. Гүрбазар, Монгол Улсын Ардын Уран Зохиолч Б. Догмид зэрэг 160 гаруй зочид төлөөлөгчид оролцлоо. Хуралд оролцсон илтгэгчдэд Аймгийн Засаг дарга О. Батжаргал хүндэтгэл үзүүлж илтгэгч тус бүрт талархал, мөнгөн урамшуулал гардууллаа. Эрдэм шинжилгээний хурлыг 200 гаруй сонсогчдод танхимаар, шууд дамжуулалтаар 3300 хүн үзсэн байна. Гадаадын эрдэмтэн судлаачид Данзанравжааг Монголын нийгмийн амьдралыг шинэчлэгч, урлаг соёлын гарамгай зүтгэлтэн, их соён гэгээрүүлэгч хэмээн судалгааныхаа бүтээлд олонтаа дурьдаж, ийм богино наслахдаа амьдарсан хугацаандаа амжихааргүй их зүйлийг бүтээжээ хэмээн гайхан биширдэг билээ. Энэ арга хэмжээг аймгийн Засаг даргын А/373-р захирамжаар 18.300,000 төгрөгөөр санхүүжүүлээ.



2023 онд говь, тал нутгийн онцлог шингэсэн соёл урлагийн үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэн “Оюу-ай”, “Тусгаар тогтнолын дуулал” яруу найргийн наадам, Хамарын хийд-Хан Баянзүрх чиглэлийн хөтөч тайлбарлагч бэлтгэх сургалт, нутгийн зохиолч яруу найрагчдын “Хутагтын говиос эгшиглэсэн аялгуу, цадиг” шилдэг уран бүтээлийн цэнгүүн зэрэг томоохон эвент арга хэмжээг зохион байгуулж 4000 иргэнд хүргэлээ. Дорноговь аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын дэргэд “Авьяас” хүүхдийн дугуйлан, аймгийн

музейн дэргэд “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлан, морин хуур, ятга, хөгжмийн болон ерөөл магтаал сургах зэрэгт 400 гаруй суралцагчид хамрагдаж байна. ЮНЕСКО-ийн төслийн хүрээнд уртын дууг битүү амьсгаагаар лимбэдэх арга барил эзэмшүүлэх сургалтаар 10 өвлөн уламжлагчид зааж сургалаа.



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 264 дүгээр тогтоолоор “2023-2025 оныг Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Монгол улсын Соёлын яамнаас зохион байгуулсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль 2023 оны 08-р сарын 18-21-ний өдрүүдэд Улаанбаатар хот, Налайх дүүргийн “Тайж хайрхан”-ы бэлд зохион байгуулагдлаа. Энэхүү наадамд Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар, Музей сургалт судалгааны төв, “Саран хөхөө” театр, Нийтлэг үйлчилгээний газар, Сайншанд сумын Засаг даргын Тамгын газар хамтран 42 оролцогч, зохион байгуулалтын 15 ажилтан зэрэг нийт 57 хүн оролцлоо. Аймгийн Засаг даргын А/586 дугаартай захирамжаар орон нутгийн төсвөө нийт 30.000.000 /гучин сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлж 8 сарын 15-ны өдрөөс эхлэн бэлтгэл ажлыг хангаж, фестиваль зохион байгуулагдах газарт язгуур урлагийн гэр, гар урлалын гэр, хүндэтгэлийн өргөө бүхий 6-8 ханатай 3 гэрээр отог байгуулан ажиллалаа. Ерөнхий найруулагчаар МУСТА Б. Баттөмөр, туслах найруулагчаар МУСТА Х. Болдбаатар нар ажиллаж 7 сумын өвлөн уламжлагчдыг хамруулж соёлын биет бус өвийн 7 ай савын хүрээнд лимбэний битүү амьсгаа, шагайн харваа, боржигин морин хуур тоглох урлаг зэрэг говь нутгийн онцлог өв соёлоо дэлгэн үзүүлж 40 минутын отгийн үзүүлбэр тоглолтыг найруулан дэглэж өдөрт 6 удаагийн давтамжтайгаар үзүүлэн тоглож, фестивалийн их тайзнаа 8 номер бүхий 30 минутын тоглолт толилуулж уламжлалт гар урлалын ай савын модон эдлэлийн урлал төрлөөр өвлөн уламжлагч Э.Батбаатар нь уламжлалт гар аргаар урласан монгол модон ширээ, бурхны гүнгэрваа бүтээлээр, модон сийлбэрийн урлал төрлөөр Хатанбулаг сумаас Ц. Аядъяасүрэн нь оньсон тоглоом, үхэр гэр тэрэг, таван хошуу малын модон сийлбэрүүдээ дэлгэж, лимбэ хөгжмийн урлалаар МУСТА Б. Отгондүү, эсгий, тэмээний ноосон урлалын төрлөөр Хатанбулаг сумын өндөр настан 78 настай Д. Аядхүү нь уламжлалт гар урлалын ай савын эсгий хийх арга ухаан, тэмээн ноосон урлал төрлөөр оролцлоо. Д.Аядхүү нь тус аймгаас оролцож буй оролцогчдоос хамгийн өндөр настан бөгөөд энэхүү арга ухааныг өвлөн аваад 60 гаруй жил болж байгаа бөгөөд өдгөө 10 гаруй шавьд өвлөн уламжлуулсан байна. Морин хуур хөгжим урлалын төрөлд Д. Уламбаярын бүтээсэн морин хууруудыг дэлгэж гар урлалын гэрийн үзэсгэлэнг дэглэж ийнхүү энэ удаагийн “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Дорноговь аймаг нь өөрийн нутгийн онцлогийг харуулсан соёлын биет бус өвийн төрлүүдээр амжилттай оролцлоо.



Монгол Улсын Төрийн өргөмжлөлт ерөөлч, магтаалч, халх туульч Зундуйн Чулуунбаатарын нэрэмжит өвийн наадам 2023.09.23-ны өдөр Мандах сумын нутаг хадан тохионы задгай тайзнаа өргөн дэлгэр болж өндөрлөлөө. Тус наадмыг соёлын биет бус өвийн эх хэл аман илэрхийллийн томоохон төрөл ерөөл, магтаал, тууль, домог, тэмээний цол морины цол зэрэг аман билгийн өвийг хөгжүүлэх хойч үед сурталчлан таниулж, Дорноговь аймгийн Мандах сумаас төрөн гарсан Монгол улсын төрийн өргөмжлөлт ерөөлч, магтаалч, туульч, хөөмийч, морин хуурч Зундуйн Чулуунбаатарын зохиол бүтээлийг сурталчлан уламжилж морин хуурчдын урын санг түүний бүтээлүүдээр баяжуулах, хүүхэд залуучууд өвлөн уламжлагчдын авьяас билгийг нээн хөгжүүлэх багш шавийн уламжлалыг дэмжих зорилгыг агуулан зохион байгуулсан.

Наадмыг Мандах сумын ИТХ, сумын ЗДТГазар санаачлан, Аймгийн Засаг дарга О. Батжаргал орон нутгийн төсвөөс 8.000.000 /найман сая/ төгрөгийн дэмжлэг үзүүлсэн бөгөөд 10 гаруй байгууллага хамтран оролцож 9 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс оролцогчид оролцсон юм. Мөн гэр бүл, үр хүүхдүүдийнх нь зүгээс язгуур урлагийн өвийн төлөө "ЗУНДУЙН ЧУЛУУНБААТАР САН"-г үүсгэн байгуулж Монголын язгуур урлагийг хөхиүлэн дэмжих, өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, судлан сурвалжлах, өв соёлын үйл ажиллагаа, ардын аман билгийг хойч үедээ өвлүүлэх их үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор үйл ажиллагаагаа эхлүүлж буйгаа зарлаад энэхүү томоохон арга хэмжээгээр эхний ажлын үр дүнгээ амжилттай тамгаллаа.



Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын МУСТА Ч.Банзрагчийн нэрэмжит Соёл, спортын төвийн санаачилгаар Дэлгэрэх сумын Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар, Музей сургалт судалгааны төв хамтран "ӨВ АЛТАН ЭРДЭНЭ" өсвөрийн морин хуурч,уртын дуу дуулаачдын говийн бүсийн наадмыг зохион байгуулсан.

"ӨВ АЛТАН ЭРДЭНЭ" өсвөрийн морин хуур, уртын дуу дуулаачдын наадамд Өмнөговь, Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 6-9, 10-12 дугаар ангийн 26 өсвөрийн авьяастан оролцсон. Тэмцээнийг морин хуурын төрлөөр дунд, ахлах насны ангилал, уртын дууны төрлөөр дунд, ахлах насаар ангиллаар тус тус зохион байгууллаа.

Наадмыг МУУГЗ, ОХУ-ын Буриад улсын СГЗ Д.Нацагдорж, МУСГЗ Л.Эрдэнэбат, МУСТА У.Чойжил нар шүүж шилдгүүдээ тодруулсан. Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газраас өсвөрийн морин хуур, уртын дуу дуулаачдын наадамд 5 сая төгрөгний мөнгөн дэмжлэг үзүүлсэн.

Морин хуурын дунд насанд:

Тэргүүн байр- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Шуурганы Амарбаясгалан

Дэд байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Бямбацогтын Чингүүн

Гутгаар байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Нэмхүүгийн Нарангэгээ

Тусгай байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Ганцэцэгийн Учрал

Тусгай байранд- Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЕБС-ийн суралцагч Ганболдын Уламбаяр

Морин хуурын ахлах насанд:

Тэргүүн байранд- Говьсүмбэр аймгийн ЕБС-ийн суралцагч Асарвааны Мөнгөншагай

Дэд байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын Шагдарын Нямпүрэв

Гутгаар байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Батсуурийн Нандинчимэг

Тусгай байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБС-ийн V-р сургуулийн суралцагч Цогтбаатарын Түвшинбаяр

Тусгай байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын суралцагч З.Мягмартайван

Уртын дууны дунд насанд:

Тэргүүн байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын суралцагч Бямбацогтын Дэлгэрзаяа

Дэд байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын суралцагч Сэргэлэнгийн Ууганжаргал

Гутгаар байранд- Говьсүмбэр аймгийн суралцагч Б.Минжин

Тусгай байранд- Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЕБС-ийн суралцагч Бадамсэдийн Бямбатуяа

Тусгай байранд- Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЕБС-ийн суралцагч Бөхбатын Болорхатан

Уртын дууны ахлах насанд:

Тэргүүн байранд- Говьсүмбэр аймгийн суралцагч Өлзий-Отгоны Энхжаргал

Дэд байранд- Дорноговь аймгийн Сайншанд сумын суралцагч Мөнх-Эрдэний Сугирмаа

Гутгаар байранд- Говьсүмбэр аймгийн суралцагч Наранхүүгийн Лхагва-Эрдэнэ

Тусгай байранд- Говьсүмбэр аймгийн суралцагч Батбаярын Түвшинсайхан шалгарсан.



Уламжлал болсон “Үндэсний номын баяр-2023” арга хэмжээг өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж “Үндэсний бичиг соёл номын өдөр- 2023” арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 6,900,000 төгрөгийг аймгийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэн дэмжлэг үзүүлээ.Номын баярын арга хэмжээнд нийт 600 гаруй иргэд, уншигч, хүүхэд багачууд хамрагдлаа. Тус арга хэмжээнд Яруу найрагч” Болор цом”-ын эзэн Б.Галсансүх Ш.Лхамноржмаа, Нацагдоржийн нэрэмжит шагналт хүүхдийн зохиолч Н.Мандал, мөн хүүхдийн зохиолч Наранцэцэг, Зохиолч Наранбаатар, Энх-Амгалан нар урилгаар ирж хүүхэд багачууд, иргэд хөдөлмөрчдөд шүлэг зохиолоо уншиж, Grand book, Day book, Үлэмжийн чанар зэрэг номын худалдаа, Зохиолчид өөрсдийн гарын үсэгтэй номыг худалдаалан хамтран ажилласан. Энэ үеэр аймгийн бүтээлч үйлдвэрлэгч “Ханна Анна” кофе шоп иргэд хүүхэд багачуудад үйлчлэн ажилласан. Мөн ном сурталчлах зорилгоор өвөрмөц санаа шийдлээр хийсэн “Том ном”-н үзэсгэлэн хүүхдийн гар урлал, үндэсний уран бичвэрийн үзэсгэлэн гаргаж олны хүртээл болгож орчныг чимэглэн асар майхан барьж зүлэг дэвсэж жижиг хэлбэрийн монгол гэр, чихмэл тоглоомууд дэлгэн хүүхдэд таатай орчинг бүрдүүлснээрээ өмнөх жилүүдээс онцлог байлаа. Хүүхдүүдийн дунд мэдлэг оюуны “АХА” тэмцээн, флаш моб, хутагтын бүтээлийг анги хамт олноороо унших зэрэг олон талт арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. “ Үндэсний бичиг соёл, номын өдөр” арга хэмжээг 13 сум зохион байгуулж нийт 1000 гаруй хүүхэд болон 500 гаруй уншигч иргэдийг хамруулан үзэсгэлэн гаргаж, уралдаан тэмцээн зохион байгуулж ажилласан.Сайншандад анх удаа Улаанбаатар хотоос номын худалдаа ирж хямд үнээр үйлчлэн хуруун хүүхэлдэйгээр зохиол уншиж хүүхдүүд шимтэн сонсож олны талархлыг хүлээлээ. “Тэргүүний уншигч Д.Нацагдорж” тэмдэгээр 6 уншигч, Тэргүүний хамт олноор ЕБС –ийн 1 анги хамт олныг шалгаруулан мөнгөн урамшууллаар шагналаа. Ноён хутагтын 220 жилийн ой угтаж Хутагтын бүтээлийг хамт олноороо цээжлэн унших аян зарласныг дүгнэн шагналуудыг гардууллаа.



Соёлын бүтээлч үйлдвэрлэл

“Эгшиглэнт говь” сумдын соёлын өдрийн арга хэмжээний хүрээнд 14 сумын Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. “Эгшиглэнт говь” соёлын өдрийн үзэсгэлэн худалдаанд 14 сумын 420 төрлийн гар урлал, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг дэлгэн үзүүлж 150 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцож 3500 гаруй хүн үзэж сонирхсон. Монгол Улс даяар өрнөж буй “Соёлын сэргэлт-2023” аяны хүрээнд аймгийн бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч 10 иргэн, 3 аж ахуй нэгжийн бүтээлийг аймгийн төв талбайд дэлгэн үзүүлж 500 гаруй иргэн оролцсон. “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд уламжлалт гар аргаар урласан монгол модон ширээ, бурхны гүнгэрваа бүтээлээр, модон сийлбэр, оньсон тоглоом, үхэр гэр тэрэг, таван хошуу малын модон сийлбэрүүдээ дэлгэж, лимбэ хөгжим, эсгий, тэмээний ноосон урлал, морин хуур хөгжим урлалын төрөлд Д. Уламбаярын бүтээсэн морин хууруудыг дэлгэж гар урлалын гэрийн үзэсгэлэнг дэглэж олон нийтийн хүртээл болгосон.Мөн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асарт Загасгал цай, Чулуун гоёл, Эко саван, монгол малгай урлал зэрэг

орон нутгийн онцлох брэнд бүтээгдэхүүнүүдийг борлуулан, үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 480 хүнд үйлчилгээ үзүүлээ.



Ноён хутагтын наадам

“Нээлттэй Дорноговь” жил болон Ноён хутагт Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан зураач, барималч, урчуудын дунд "НОЁН ХУТАГТ ДАНЗАНРАВЖАА" уран бүтээлийн улсын уралдааныг зарлан дүгнэж үзэсгэлэн гаргаж нийтэд сонирхууллаа. Аймгийн Засаг дарга орон нутгийн төсвөөс 23.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн аймгийн Соёл урлагийн газар, Монголын урчуудын эвлэл, аймгийн Музей, сургалт судалгааны төв хамтран МСССТ-ийн үзэсгэлэнгийн танхимд 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа. “Ноён хутагт Данзанравжаа” уран бүтээлийн үзэсгэлэнгийн нээлтэнд МСССТ-ийн дэргэдэх “Эвийн эгшиг” уртын дууны дугуйлангын 19 суралцагчид “Уяхан замбутивийн наран” дууг дуулж Аймгийн Засаг дарга О. Батжаргал нээж үг хэллээ. Нээлтийн үйл ажиллагааг 60 гаруй иргэд үзэж сонирхлоо.

Үзэсгэлэнд нийт 28 уран бүтээлчийн 58 бүтээл ирсэнээс 23 бүтээл дэлгэгдэж уралдааны шүүгчдээр:

МУЭ-ийн Ерөнхийлөгч П.Ганбат

МУЭ-ийн гишүүн зураач МУСГЗ Н.Орхон

МУЭ-ийн гишүүн зураач, АГО З.Уянга

МУЭ-ийн гишүүн зураач, ДУА-ийн Уран зургийн тэхимийн эрхлэгч, МУСТА Г.Амарсанаа

МУЭ-ийн гишүүн, уран барималч Б. Лхагважав нар ажилласан бөгөөд үзэсгэлэнгийн дэглэлтийг Музей, сургалт судалгааны төвийн ажилчид Монголын урчуудийн эвлэлийн гишүүн зураачид хамтран дэглэлээ.

Шилдгийн шилдэг гранпри шагналын бүтээлээр Дорноговь аймгийн харъяат, Монголын Урчуудын эвлэлийн гишүүн зураач Б.Баярцэнгэлийн “Он цагийг гэтэлгэгч” бүтээл шалгарлаа. Уран зургийн шилдэг төрөлд Дорноговь аймгийн Хатанбулаг сумын харъяат урлагийн гавъяат зүтгэлтэн, ардын зураач Л.Гаваагийн хүү зураач Төмөрийн “Хан Баянзүрх хайрхан”, зураасан зургийн шилдэг төрөлд Д.Гунгаа “Аялгуут эгшилэн”, уран баримлын шилдэг төрөлд Н. Золжаргал “Шүтээн” бүтээлүүд шилдэг бүтээлээр шалгарч, уран бүтээлийн уралдааны нэрэмжит шагналаар Г. Мөнхзаяа “Цагийн жам”, Б.Түвшинтөр “Шүтээн” бүтээлүүд тус тус шалгарлаа.



Нэрт соён гэгээрүүлэгч, говийн V ноён хутагт Дулдуйтын Данзанравжаагийн мэлмий гийсний 220 жилийн ойг тохиолдуулан “Хос морьтой сайхан хос”, “Жороо морь” тэмцээнүүдийг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Соёл, урлагийн газар, Хүнс хөдөө аж ахуйн газар хамтран зохион байгууллаа. Хос морьтой сайхан хос тэмцээнд 5 сумын 6 хос, Жороо морь тэмцээнд 6 сумын 6 иргэн оролцож, шүүгчээр Худалдаа хөгжлийн банкны захирал Д.Буянбат, Музей сургалт судалгааны төвийн чихмэлч Г.Гантулга, Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн Д.Отгонбаатар нар ажилласан.

❖ **“Жороо морь” тэмцээнд:**

Тэргүүн байр - Айраг сумаас оролцогч Батчимэгийн Батравжих
Дэд байр – Сайхандулаан сумаас оролцогч Марахайн Чинзоригт
Гутгаар байр – Замын-Үүд сумаас оролцогч Дашням

❖ **“Хос морьтой сайхан хос” тэмцээнд:**

Тэргүүн байр – Даланжаргалан сумаас оролцогч Төмөрчулууны Батгэрэл,
Цэмбэлдоржийн Мөнхзаяа /Хар морьтой/
Дэд байр – Эрдэнэ сумаас оролцогч Өвгөний Отгонбаяр, Даваагийн
Оюунчимэг /Цоохор морьтой/
Гутгаар байр – Хөвсгөл сумаас оролцогч Гүнгэрэгийн Мөнхбат, Лоохорын
Намуунбайгаль /Хүрэн халзан морьтой/
Шагналт 1,2,3-р байрыг тус бүр шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар
/500.000, 400.000, 300.000 төгрөг/ шагналаа.



Улс, бүсд гаргасан амжилтуудаас, аймгаас хэрхэн дэмжсэн талаарх мэдээлэл

Хүүхэд, өсвөр үеийнхний авьяас чадварыг хөгжүүлэх, шинэ авьяастан төрүүлэх, бүжгэн дэгийн өв, урын санг баяжуулж сурталчлан таниулах, урлагаар дамжуулан хүүхэд багачуудад гоо зүйн хүмүүжил төлөвшил олгох, соёлын өв, уламжлалт бүжгийн урлагийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Монгол Улсын төрийн шагналт, ардын жүжигчин, зууны манлай бүжиг дэглээч Ц.Сэвжидийн нэрэмжит "Өсвөрийн бүжигчдийн улсын XVI наадам"-ийн удирдамж төсвийг Аймгийн Засаг даргын А/283 тоот захирамжаар шийдвэрлүүлэн Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Саран хөхөө театр хамтран Сайншанд хотноо 2023 оны 05 сарын 20,21 өдрүүдэд зохион байгууллаа. Уг наадамд Дорноговь аймгийн 1,2,5 дугаар сургууль Magic dance бүжгийн клуб, Саруул дэнж бүжгийн клуб, Замын-үүд сумын 1,2 дугаар сургууль, Айраг, Дэлгэрэх, Эрдэнэ сум Завхан, Говьсүмбэр, Хэнтий, Өмнөговь, Сэлэнгэ, Өвөрхангай, Төв зэрэг 8 аймаг Чингэлтэй, Баянзүрх, Багануур, Хан-Уул 4 дүүргийн нийт 654 хүүхэд хамтлаг бүжиг болон гоцлол бүжгийн төрөлд тус бүрдээ 3 насны ангиллаар оролцлоо. Бүжгийн наадмын шүүгчээр Урлагийн гавьяат зүтгэлтэн, МУАХ-ын Бүжгийн зөвлөлийн тэргүүн Ч.Даваасүрэн, Урлагийн гавьяат зүтгэлтэн, СУИС бүжгийн урлагийн сургуулийн захирал Д.Баярбаатар, Ц.Сэвжидийн нэрэмжит Бүжгийн чуулгын тэргүүн А.Баярсайхан нар ажиллалаа. Наадмын 2 өдөр анхан болон шалгаруулах шатны тоглолтуудыг 1500 гаруй эцэг эхчүүд болон хүүхэд багачуудад үнэ төлбөргүй сонирхуулсан. Шагнал урамшуулалд зориулан Аймгийн Засаг даргын 2023 оны

А/283 -р захирамжаар 29,090,000 төгрөгийг шийдвэрлэн дэмжлэг үзүүлснээс гадна Хөдөлмөрийн баатар, бүжиг дэглээч Сэвжид агсны хүү Сүхбаатарт аймгийн Засаг даргын зүгээс хүндэтгэл үзүүлж мөнгөн шагнал гардууллаа.



Нэрт Соён гэгээрүүлэгч Дулдуйтын Данзанравжаагийн 220 жилийн ойд зориулан Соёлын яамнаас "Хүүхдийн соёлын их наадам"-ын хүрээнд "Говийн хүүхдүүд" урлагийн наадмыг Дундговь аймгийн Адацаг сумын нутагт орших "Сүм хөх бүрд" байгалийн үзэсгэлэнт цогцолборт газар зохион байгуулсан. Уг наадмыг Нэрт соён гэгээрүүлэгч Ноён хутагт Данзанравжаагийн уран бүтээл, өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн үлдээх зорилгоор говийн бүсийн Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь аймгуудын дунд 80 гаруй хүүхэд, багачуудыг оролцуулан 2023 оны 9 дүгээр сарын 7,8-ны өдрүүдэд зохион байгууллаа. Наадмын шүүгчээр Төрийн шагналт, УГЗ, зохиолч, яруу найрагч Ш.Гүрбазар, МУАЖ уртын дууч А.Нэргүй, МУГЖ уртын дууч Г.Хонгорзул, түүхийн ухааны доктор, дэд профессор Ц.Минжин, бүжигчин Б.Эрдэнэтуяа нар ажилласан. Дорноговь аймгийн Соёл, урлагийн газар урлагийн наадамд зориулан 20 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн 2-р сургуулийн "Говийн уянга" хамтлаг, 5-р сургуулийн "Болор эгшиг" хамтлаг, Музей сургалт судалгааны төвийн дэргэдэх "Эвийн эгшиг" уртын дууны дугуйлангийн хүүхдүүд болон Т.Одончимэг, Н.Ундрах, Б.Баттайван, Ч.Цэрэндэжид, Х.Данзанравжаа гэсэн 24 хүний бүрэлдэхүүнтэй оролцож ирсэн. "Говийн хүүхдүүд" урлагийн наадамд Дорноговь аймаг 4 төрлийн 7 бүтээлээр оролцож:

Бэсрэг уртын дуу гоцлол төрөлд Г. Цэлмэг ТЭРГҮҮН БАЙР

Чөлөөт бүтээлээр найруулсан гоцлол төрөл А. Анударь ДЭД БАЙР

Чөлөөт бүтээлийн хамтлаг төрөл "Говийн уянга" ДЭД БАЙР

Бэсрэг уртын дуу хамтлаг "Эвийн эгшиг" ГУТГААР БАЙР эзэлж бусад говийн аймгуудаа тэргүүлэн оролцлоо.

